



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 66

Мандалговь

**Б.Уугансарнайг Адаацаг сумын
цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 6 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Адаацаг сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Бидэргарав овогтой Уугансарнай 62.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Уугансарнайн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



**Адаацаг сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд
нэр дэвшүүлсэн Б.Уугансарнайгийн тухай дүгнэлт**

1. Б.Уугансарнай нь 1991 онд Дундговь аймгийн Адаацаг суманд төрсөн. 31 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2013-2017 онд МУБИС-ийн СӨБС-ийн цэцэрлэгийн багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Б.Уугансарнайгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Адаацаг сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ